

2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 6 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн. ГССҮТ, УАУХТ эмнэлгүүд хүлээгдлийн мэдээ ирүүлээгүй байна.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2019 оны 8 дугаар сард СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна. Нийт хүлээгдэл 527 бүртгэгдсэн. Өдөртөө үйлчлүүлсэн 737 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Үүнд: УНТЭ 18 хүлээгдэл, **УХТЭ 129 хүлээгдэл, УГТЭ 120 үйлчлүүлэгч, ХСҮТ 260 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна.**

УНТЭ-ийн амбулаторийн нэг кабинетэд 18 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 76 үйлчлүүлэгчийн хүлээгдээр буурсан байна. Үүнд: Урологийн кабинетэд 18 хүлээгдэл 2 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 8 кабинетэд 129 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: Бөөр судлалын кабинет 2, зүрх судасны кабинет 24, уушигны кабинет 1, мэдрэл судлалын кабинет 28, нүдний кабинет 3, булчирхай судлалын кабинет 2, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 64, эмэгтэйчүүдийн кабинет 5 үйлчлүүлэгч тус тус 2-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетэд 204 үйлчлүүлэгч байна.


УГТЭ-т 6 кабинетэд нийт 120 хүлээгдэл бүртгэгдсэн **нь өмнөх сарын хүлээгдлээс 65 хүлээгдлээр нэмэгдсэн байна.**

Үүнд: Зүрх судасны кабинетэд 40, мэдрэлийн кабинет 16, чих хамар хоолойн кабинетэд 12, хоол боловсруулах эрхтэн системийн кабинет 21, зүрхний мэс засал 25, мэдрэлийн мэс заслын кабинет 6 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 14 кабинетэд 404 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 260 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 42 хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд: Зүрх судасны кабинет 10, мэс заслын кабинет 3, цээжний хөндийн мэс засал 48, элэг цөс нойр булчирхайн кабинет 50, сэргээн засах кабинет 1, толгой хүзүүний мэс заслын кабинет 23, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 21, гепатологийн кабинет 13, туяа эмчилгээний кабинет 20, хими эмчилгээний

кабинет 45, хөнгөвчлөх 1, ангиографийн кабинет 25 үйлчлүүлэгч тус бүр 2-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 129 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УНТЭ, УГТЭ-ийн 2019 оны 8-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 8-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 8 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад 537 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 474 үйлчлүүлэгч байна.

УНТЭ-т оношлуулахаар 106 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна.

Үүнд: Хэвлийн эхо 59, MRI 20, захын судасны ЭХО 10, бүдүүн гэдэсний дуран 3, КТГ 1, урологийн оношилгооны дуран 13 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 171 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд: Рентген зураг 49, зүрхний цахилгаан бичлэг 18, хэвлийн эхо 66, ходоодны дуран 37, доплерографи 1 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 143 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 81 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд: Рентген зураг 32, зүрхний цахилгаан бичлэг 25, хэвлийн эхо 24 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 110 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 275 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 122 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 76 үйлчлүүлэгч, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 30 үйлчлүүлэгч байна. Нийт хүлээгдэл 106 байна.

Үүнд: Ходоодны дуран 22, хэвлийн ЭХО 63, зүрхний цахилгаан бичлэг 10, бүдүүн шулуун гэдэсний дуран 1, рентген харалт 10 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 122 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 73 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 83 өдөртөө, 8 үйлчлүүлэгч 2 хоног, 3-14 хоногийн хүлээгдэлтэй 65 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 83 үйлчлүүлэгч байна.

ЭХЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетийн 8-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:

Оношилгооны хүлээгдэл	УНТЭ	УХТЭ	УГТЭ	ХСҮТ	СЭМҮТ	Нийт
Рентген зураг		49	32			32
Рентген харалт				10		10
Зүрхний цахилгаан бичлэг		18	25	10		35
Хэвлийн ЭХО	59	66	24	63		146
Ходоодны дуран		37		22		22
Урологийн оношилгооны дуран	13					13
Эмгэг сэтгэл судлал					73	73
Бүдүүн гэдэсний дуран	3			1		4
Захын судасны ЭХО	10					10
Допплерографи		1				
MRI	20					
КТГ	1					
Нийт	106	171	81	106	73	345

Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 8 сарын лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 8 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

Лабораторийн нийт хүлээгдэл 405, өдөртөө үйлчлүүлсэн 500 үйлчлүүлэгч байна.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 355 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 23, шээсний ерөнхий шинжилгээ 22, биохими 270, бактериологийн шинжилгээ 16, иммунологийн шинжилгээ 10, сериологийн шинжилгээ 2, коагулограммын шинжилгээ 12 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 269 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн хүлээгдэл 50 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 13, биохимийн шинжилгээ 28, үйлчлүүлэгч, иммунологи 9 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Шээсний ерөнхий шинжилгээ, бактериологи, серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 231 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 8-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 8 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ ЭХЭМҮТ, НЭМГ бүртгэн мэдээлсэн.

Нийт хүлээгдэл 820 үйлчлүүлэгч хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. ЭХЭМҮТ, УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 8-р сард нийт 231 үйлчлүүлэгч 3 хоногоос 14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 14, зүрх судасны системийн тасагт 20, мэс заслын тасагт 140, мэдрэлийн тасагт 14, уламжлалт эмчилгээний тасагт 38, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 5 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 8-р сард нийт 202 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Зүрх судасны тасагт 14, уушигны тасагт 5, зүрхний мэс заслын тасагт 4, чих хамар хоолойн тасагт 70, мэдрэлийн тасагт 4, мэдрэлийн мэс засалд 109 үйлчлүүлэгч тус тус 3-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 8-р сард нийт 170 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 63 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 69 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 28 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна. Элэг цөс нойр булчирхайн тасагт 40, хөнгөвчлөх эмчилгээ 21, хими эмчилгээ 76, мэдрэлийн мэс засал 109, ангиограф 33 үйлчлүүлэгч 3-30 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн 8-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 73 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

Үүнд: 8 үйлчлүүлэгч 3-6 хоног, 24 үйлчлүүлэгч 7-14 хоног, 41 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 15 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (2019 оны 8 сар):

СЭМҮТ-ИЙН НЕВРОЗЫН ТАСГИЙН ХҮЛЭЭГДЭЛ



Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харьяа 9 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн мэдрэл 48, БГДЭМТ-ийн мэдрэл 31, дотор 79, ЧДЭМТ-ийн дотор 93, БЗДНЭ-ийн дотор 141, ахмадын эмнэлэг 82 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 8-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 8 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	8 сар								
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	СХД НЭ
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	48	6	0	6	3	31	0	0	0
		1-3 хоног	12	6		6		4			
		3-6 хоног	28				2	15			
		7-14хоног	6				1	12			
		15-30 хоног	2								
		1 сараас дээш									
2	Дотор	Ор хүлээж байгаа	79	53	60	43	5	32	198	0	0

		ӨВЧТНИЙ ТОО									
		1-3 хоног	1	23	39	14		2	63		
		3-6 хоног	11	17	16	11	2	12	80		
		7-14хоног	40	13	5	18	3	18	35		
		15-30 хоног	27	0					20		
		1 сараас дээш		0							
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	35	0	0	0	0	38	0	0	0
		1-3 хоног						11			
		3-6 хоног						5			
		7-14хоног	12					17			
		15-30 хоног	23					5			
		1 сараас дээш									
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног									
		3-6 хоног									
		7-14хоног									
		15-30 хоног									
		1 сараас дээш									
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног									
		3-6 хоног									
		7-14хоног									
		15-30 хоног									
		1 сараас дээш									
7	Нарколог-ийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног									
		3-6 хоног									
		7-14хоног									
		15-30 хоног									
		1 сараас дээш									

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 8-р сард 30234 дуудлага бүртгэгдсэний 35.9%-ийг 0-20 минутад, 33.5%-ийг 21-40 минутад, 17.1%-ийг 41-60 минутад, 13.5 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 8 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 3.9%-иар буурсан, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 5 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны сүүлийн 6 сард
ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА